



МОНГОЛ УЛСЫН СТАНДАРТ

**Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй
Сургалтын зохион байгуулалт. Үндсэн дүрэм**

MNS 4969 : 2000

Албан хэвлэл

**СТАНДАРТЧИЛАЛ, ХЭМЖИЛЗҮЙН ҮНДЭСНИЙ ТӨВ
УЛААНБААТАР ХОТ
2000 он**

Өмнөх үг

Энэ стандартыг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын хяналтын алба хянаж шинэчлэн боловсруулав.

Стандартын төслийг ТХ/17 Хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны стандарчиллын техникийн хороогоор хэлэлцэж зөвшилцсөн болно.

Анхны үзлэгийг 2004 онд, дараа нь 5 жил тутамд

Стандартчилал, хэмжилзүйн үндэсний төв (СХҮТ)

Энх тайваны өргөн чөлөө 46 А

Улаанбаатар – 211051, Ш/Х-48

Утас: 457765, 451810 Факс: 976-11 458032

E-mail: mncsm@magicnet.mn

© СХҮТ-2001

Стандартчилал, чанарын баталгаажуулалтын тухай хуулийн дагуу энэхүү стандартыг бүрэн, эсвэл хэсэгчлэн хэвлэх, олшруулах эрх нь гагцхүү СХҮТ (Стандартчилал, баталгаажуулалтын төв байгууллага) - д байна.

МОНГОЛ УЛСЫН СТАНДАРТ

Ангилалтын код 13.100

Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй. Сургалтын зохион байгуулалт. Үндсэн дүрэм Occupational safety and health. Organisation of training. Basic rule	MNS 4969 : 2000
	MNS 12.0.004 : 85-ын оронд

Стандартчилал, хэмжилзүйн үндэсний төвийн Зөвлөлийн 2000 оны 06 дугаар сарын 29-ний өдрийн 105 тоот тогтоолоор батлав.

Энэхүү стандарт нь 2000 оны 7 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн хүчинтэй.
Энэ стандартын норматив шаардлагыг заавал мөрдөнө.

1 Хамрах хүрээ

Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн сургалтыг сургуулийн өмнөх насны хүүхэд, бүх шатны сургуулийн суралцагчид, шинээр давтан, хоёр дахь мэргэжлээр бэлтгэгдэж байгаа болон ажил хөдөлмөр эрхэлж байгаа ажилтан, инженер, техникийн болон удирдах ажилтанд зориулж, шат шатанд нь зохион байгуулна.

2 Үндсэн дүрэм

2.1 Цэцэрлэгийн насны хүүхдэд осол, аюулын талаар анхдагч зөв ойлголт өгөх тоглоом наадгай, ахуйн хэрэгсэл, материалтай харьцах, зөв болон бурууг ялгах чадвар олгох, аливаа үзэгдэл, хөдөлгөөнийг зөв гүйцэтгэх, ариун цэвэр эрүүл ахуйн анхны хэвшил төлөвшүүлэх ажлыг сургалтын үлгэрчилсэн хөтөлбөрт тусгаж хэрэгжүүлнэ.

2.2 Бага боловсрол эзэмших суралцагчдад аливаа аюултай, хортой үзэгдэл, юмс, эрүүл ахуйн талаар анхан шатны мэдлэг олгож, түүнийгээ амьдрал ахуйдаа хэрэглэх чадал чадвартай болгохын зэрэгцээ түүнийг өөрийн болон бусдын хөдөлмөрийн хүндэтгэх үзлээр хүмүүжүүлнэ.

2.3 Суурь боловсрол эзэмших суралцагчдад аливаа хортой, аюултай үзэгдэл юмсын талаар шинжлэх ухааны суурь мэдлэг эзэмшүүлж, түүний үндсэн дээр өөрийн мэдлэг чадвараа цаашид хөгжүүлж, бие даан ажиллахад шаардлагатай мэдлэг, чадвар дадлыг олгох ба аюулгүй ажиллагаа эрүүл ахуйн дэг журам, дүрмийг чанд сахидаг үзлээр хүмүүжүүлнэ.

2.4 Бүрэн дунд боловсрол эзэмших суралцагчдад хими, физик, биологийн аюултай ба хортой хүчин зүйлийн тухай шинжлэх ухааны ойлголт, хуулиудыг танин мэдүүлэх, мэргэжлийн чиг баримжаа олгож, бие даан аюулгүй ажиллах арга барилд сургах, чадвар дадал олгохын зэрэгцээ хууль ёсыг дээдлэн сахидаг үзэл төлөвшүүлнэ.

2.5 Их сургууль, коллежийн суралцагчдад, ялангуяа үйлдвэрлэл, техник технологи, анагаах ухаан, эрүүл ахуйн чиглэлээр мэргэжиж байгаа суралцагчдад хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн асуудлаар онолын үндсийг эзэмшүүлж, түүнийг амьдрал, хөдөлмөрт төлөвшүүлнэ. Үйл ажиллагаандаа хэрэгжүүлэх, бусдыг сургаж зааварчлах чадвар, дадал эзэмшүүлнэ.

2.6 Их сургууль, коллежийн дээд боловсролын дипломын болон бакалаврын зэргээр төгсөх оюутны дипломын төсөлд хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн асуудлаар нэг хэсэг болгон тусгаж, улсын шалгалтын комисс үнэлэлт өгнө.

2.7 Их сургууль, коллежийн дээд боловсролын дипломын болон бакалаврын зэрэг олгох сургалтын төлөвлөгөөнд тусгах ХААЭА-н холбогдолтой хичээлийн кредит цаг, агуулгыг боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, холбогдох мэргэжлийн бусад байгууллагатай хамтран боловсруулан мөрдүүлнэ.

2.8 Үйлдвэрлэлийн шинж чанар, хортой аюултай байдлын зэрэглэлийг харгалзахгүйгээр хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн сургалтыг дараах үе шатаар зохион байгуулна.

Үүнд:

а/ Шинээр ажилтан бэлтгэх үеийн хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн сургалт

б/ Үйлдвэр аж ахуйн нэгж, байгууллага дахь хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн сургалт

в/ Мэргэжил дээшлүүлэх үеийн хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн сургалт

2.9 Үйлдвэр, аж ахуйн нэгж, байгууллагын удирдах ажилтан (дарга, захирал, эрхлэгч), шинээр аж ахуй эрхлэх гэж буй хүмүүс хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн тусгай сургалтад хамрагдана.

2.10 Үйлдвэр, аж ахуйн нэгж, байгууллага бүр ажилтнаа жилд нэгээс, доошгүй инженер, техникийн ажилтнаа 2-3 жилд нэгээс доошгүй удаа хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн сургалтад хамруулна.

2.11 Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн сургалтыг зохион байгуулах, удирдлагаар хангах ажлыг үйлдвэр, аж ахуйн нэгж, байгуулагад тухайн байгууллагын дарга болон хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн ажил хариуцсан ажилтан хэсэг, нэгжид тэдгээрийн дарга (мастер) хариуцна.

2.12 Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн тусгай шаардлага тавигддаг, аюултай ажил гүйцэтгэдэг ажилтан бэлтгэх сургалтын хөтөлбөрийг төрийн захиргааны уг асуудал хариуцсан байгууллага зөвшөөрсөн байна.

3 Шинээр ажилтан бэлтгэх үеийн хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн сургалт

3.1 Шинээр ажилтан бэлтгэх үеийн хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн сургалтыг энэ асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаас гаргасан удирдамж, хөтөлбөрийн дагуу зохион байгуулна.

3.2 Шинээр ажилтан бэлтгэх сургалтын хөтөлбөрт хөдөлмөрийн хууль тогтоомж, хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн стандартын холбогдох шаардлагыг заавал оруулна.

3.3 Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн арга барил эзэмшүүлэх үйлдвэрлэлийн дадлагыг дадлага хийх зориулалтын газар (цех, тасаг)-т буюу

ажлын байранд хэсэг, цехийн дарга, мастер, өндөр мэргэжилтэй ажилтан, мэргэжлийн багш удирдаж хийлгэнэ.

3.4 Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн талаар олсон мэдлэгийг тогтоосон журмын дагуу шалгах ба тэнцээгүй хүмүүсийг давтан сургалтад хамруулж дахин шалгалт авна.

4 Үйлдвэр аж ахуйн нэгж, байгууллага дахь хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн сургалт

4.1 Үйлдвэр, аж ахуйн нэгж, байгууллага дахь хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн сургалтыг зааварчилга өгөх хэлбэрээр зохион байгуулна.

Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн зааварчилга дараах 3 хэлбэртэй байна. Үүнд:

1. Урьдчилсан зааварчилга
2. Ажлын байран дахь анхан шатны зааварчилга
3. Давтан зааварчилга

4.2 Зааварчилгын хөтөлбөр, хичээлийн сэдвийг хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн асуудал хариуцсан ажилтан боловсруулж, ҮЭ-ийн байгууллагатай зөвшилцсөний үндсэн дээр тухайн байгууллагын ерөнхий менежер (инженер), орлогч дарга батална.

4.3 Шинээр ажилд орсон ажилтан, үйлдвэрлэлийн сургалт, дадлага хийхээр ирсэн оюутан, суралцагчдад тэдний ажилласан жил боловсролын түвшинг харгалзахгүйгээр урьдчилсан зааварчилга өгнө.

4.4 Урьдчилсан зааварчилгын агуулга нь хөдөлмөрийн хууль, тогтоомж, хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн дүрэм, заавар, улсын стандарт, тухайн байгууллагын өвөрмөц онцлог, дотоод дүрэм, техникийн аюулгүй ажиллагаа, үйлдвэрлэлийн эрүүл ахуй, ариуйн цэвэр, галын аюулгүй байдал, хувийн хамгаалах хэрэгсэл, үйлдвэрлэлийн осол, МШӨ, хурц хордлого, үүсэх шалтгаан, осолдогчдод үзүүлэх анхны тусламж зэрэг болно.

4.5 Урьдчилсан зааварчилгыг хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн кабинет, сургалтын техник хэрэгслээр тусгайлан тоноглогдсон анги, танхимд уг асуудлыг хариуцсан удирдах буюу инженер техникийн ажилтан өгнө.

4.6 Урьдчилсан зааварчилга өгөх хугацаа нь тухайн техник технологийн салбарын аюулгүй ажиллагааны дүрэмд заасан хэмжээгээр тогтоогдох бөгөөд 2 цагаас багагүй байна.

4.7 Ажлын байран дахь анхан шатны зааварчлагыг ажилтны ажилладаг хэсэг, цех, тасаг, ажлын байр өөрчлөгдөх үед, мөн ажилд шинээр орсон болон үйлдвэрлэлийн дадлага хийхээр ирж урьдчилсан зааварчилга авсан хүмүүс, оюутан сурагчдад өгнө.

4.8 Ажлын байран дахь анхан шатны зааварчилгын агуулга нь тухайн ажилтны ажлын байрны үйлдвэрлэлийн процесс, гүйцэтгэх ажлын онцлог, машин техник, багаж, хэрэгсэл ашиглах болон ажлын явцад үүсэж болох сөрөг хүчин зүйл, түүнээс хамгаалах хэрэгсэл, тэдгээрийг ашиглах заавар, аюулгүйн ажиллагааны арга барил, үйлдвэрлэлийн өргөх тээвэрлэх машин механизм, даралтат сав,

MNS 4969 : 2000

шугам хоолой, цахилгаан тоног төхөөрөмжийн ашиглалт, аюулгүй ажиллагааны шаардлага, галын аюулгүй байдлыг хангах, журам, гал түймэр гарсан үед авах арга хэмжээ, гал унтраах хэрэгсэл, тэдгээрийг ашиглах, хадгалах, осолдогчдод үзүүлэх анхын тусламж зэрэг болно.

4.9 Ажлын байран дахь анхан шатны зааварчилгыг тухайн ажлын байрыг хариуцсан цех, тасаг, хэсгийн дарга, эрхлэгч биечлэн үзүүлэх журмаар өгнө.

4.10 Ажлын байран дахь анхан шатны зааварчилгын дараа зааварчилга өгсөн ажилтан шалгалт авч хангалттай гэж үзвэл уг ажилтанд бие даан ажиллах зөвшөөрөл олгоно.

4.11 Давтан зааварчилгыг ажилтанд өмнө олгосон мэдлэгийг бататгах, баяжуулах зорилгоор ажлын байран дахь анхан шатны зааварчилгын агуулгаар өгнө.

4.12 Давтан зааварчилга нь гурван хэлбэртэй байна. Үүнд:

а/ ээлжит

б/ ээлжит бус

в/ ажлын байран дахь өдөр тутмын

4.13 Ээлжит давтан зааварчилгыг улиралд нэгээс доошгүй удаа өгнө.

4.14 Ээлжит бус давтан зааварчилгыг шинэ технологи, машин механизм, тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл нэвтрүүлэх, хөдөлмөрийн нөхцөл өөрчлөгдөх, хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн дүрэм заавар, шинэчлэгдэж өөрчлөгдөх үед давтан зааварчилга өгөх ээлжит хугацаанаас нь өмнө өгнө.

4.15 Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн дүрэм, зааврыг ноцтой зөрчсөн хүмүүс буюу үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалан өвчин, хурц хордлого гарсан цех тасаг, хэсгийн ажилтан нарт, мөн нэг сараас илүү хугацаагаар ажлаас хөндийрч яваад эргэж ажилдаа орсон ажилтанд ээлжит бус давтан зааварчилга өгнө.

4.16 Аюултай ажил гүйцэтгэдэг хүмүүст ажлын байран дахь өдөр тутмын зааварчилга өгнө. Ажлын байран дахь өдөр тутмын зааварчилга нь товч тодорхой байх ба ажил эхлэхийн өмнө бичгээр өгөгдөнө.

4.17 Урьдчилсан, ажлын байран дахь анхан шатны, давтан болон ажлын байран дахь өдөр тутмын зааварчилгын бүртгэлийн журналд (хавсралтын 1, 2, 3-р хүснэгт)

5 Мэргэжил дээшлүүлэх үеийн хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн сургалт

5.1 Үйлдвэр, аж ахуйн нэгж, байгууллагын ажилтны мэргэжил дээшлүүлэх болон хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн курсийн сургалтыг шинээр ажилтан бэлтгэх мэргэжлийн сургалттай хамтатган жил бүр явуулна.

5.2 Инженер, техникийн болон удирдах ажилтны хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн мэдлэгийг дээшлүүлэхдээ: аж ахуйн газар, яам, тусгай газар, их сургууль, коллеж, эрдэм шинжилгээний байгууллагын дэргэдэх мэргэжил дээшлүүлэх курс, хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн тусгай курс /семинар/-т суралцуулах хэлбэрээр гүйцэтгэнэ.

5.3 Өргөх, тээвэрлэх машин механизм, даралтат сав, шугам хоолой, цахилгаан тоног төхөөрөмж химийн хортой, тэсрэх болон цацраг, биологийн идэвхт бодис хэрэглэж байгаа зэрэг хөдөлмөрийн онцгой нөхцөлд ажиллах ажилтныг мэргэжлийн болон хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн тусгай хөтөлбөрөөр сургаж, үнэмлэх олгох ба зохих эрх аваагүй ажилтныг ажиллуулахыг хориглоно.

5.5 Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн сургалтыг энэ асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаас батлан гаргасан үлгэрчилсэн хөтөлбөрийн дагуу явуулна.

ТӨГСӨВ.

**УРЬДЧИЛСАН ЗААВАРЧИЛГЫН БҮРТГЭЛИЙН
ЖУРНАЛЫН МАЯГТ**

1-р хүснэгт

1	Урьдчилсан зааварчилга авсан хүний овог нэр, ажил, албан тушаал	Зааварчилгын утга	Он, сар, өдөр	Зааварчилга өгсөн хүний албан тушаал, нэр, гарын үсэг	Зааварчилга авсан хүний гарын үсэг
1.					
2.					
3.					

**АЖЛЫН БАЙРАН ДАХЬ АНХАН ШАТНЫ ЗААВАРЧИЛГЫН
БҮРТГЭЛИЙН ЖУРНАЛЫН МАЯГТ**

2-р хүснэгт

1	Анхан шатны зааварчилга авсан хүний овог, нэр, албан тушаал	Зааварчилгын утга	Он, сар, өдөр	Шалгалтын дүн	Зааварчилга өгсөн хүний албан тушаал, гарын үсэг	Зааварчилга авсан хүний гарын үсэг	Ажиллуулахыг зөвшөөрсөн хүний	
							Албан тушаал, овог, нэр	Гарын үсэг
1								
2								
3								

**АЖЛЫН БАЙРАН ДАХЬ ДАВТАН
ЗААВАРЧИЛГЫН БҮРТГЭЛИЙН ЖУРНАЛЫН МАЯГТ**

3-р хүснэгт

1	Ажилтаны овог нэр, ажил, албан тушаал	Давтан зааварчилга өгсөн шалтгаан	Зааварчилгын сэдэв	Он, сан, өдөр	Зааварчилга өгсөн хүний албан тушаал нэр, гарын үсэг	Зааварчилга авсан хүний гарын үсэг
1						
2						
3						